



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.26 № 01/347
танай -ны № -т

ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМ
ХӨВСГӨЛ АЙМГИЙН НАМЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ГЭРЭЛТУЯА
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Иргэний хөдөлгөөний намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Иргэний хөдөлгөөний намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Иргэний хөдөлгөөний намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Иргэний хөдөлгөөний намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



Иргэний хөдөлгөөний намын Хөвсгөл аймгийн намын хорооны
Тэргүүлэгчдийн 2024 оны 06 сарын 17-ний өдрийн
011 тоот тогтоолоор батлав

**“НҮҮДЛИЙН СОЁЛТ ДЭЛХИЙН УЛС”
НҮҮДЭЛЧДИЙН ИХ УЛС МОНГОЛ
“ҮНДЭСНИЙ СОЁЛТ НҮҮДЭЛЧИН МОНГОЛ СУМ”**

ЗОРИЛГО: “Үндэсний Соёлт Нүүдэлчин Монгол Аймаг” мөрийн хөтөлбөрийн хүрээнд

1. Үндэсний Соёлт Нүүдэлчин Монгол Аймгийн нийгмийн хөгжлийн нэгдмэл эрх зүйн тогтолцоо;
2. Үндэсний Соёлт Нүүдэлчин Монгол Аймгийн бүтцийн хөгжлийн нэгдсэн эрх зүйн тогтолцоо;
3. Үндэсний Соёлт Нүүдэлчин Монгол Аймгийн удирдлагын хөгжлийн нэгдмэл эрх зүйн тогтолцоо;

АРГА ЗАМ: “Үндэсний Соёлт Нүүдэлчин Монгол Аймаг” мөрийн хөтөлбөрийн хүрээнд

1. Үндэсний Соёлт Нүүдэлчин Монгол Аймгийн “Нүүдэлчин Монгол Сум”-ын нийгмийн хөгжлийн нэгдсэн эрх зүйн зохицуулалтыг удирдан хэрэгжүүлэх;
2. Үндэсний Соёлт Нүүдэлчин Монгол Аймгийн “Нүүдэлчин Монгол Сум”-ын бүтцийн хөгжлийн нэгдсэн эрх зүйн зохицуулалтыг удирдан хэрэгжүүлэх;
3. Үндэсний Соёлт Нүүдэлчин Монгол Аймгийн “Нүүдэлчин Монгол Сум”-ын удирдлагын хөгжлийн нэгдсэн эрх зүйн зохицуулалтыг удирдан хэрэгжүүлэх;

ҮР ДҮН: “Үндэсний Соёлт Нүүдэлчин Монгол Аймаг” мөрийн хөтөлбөрийн хүрээнд

1. “Нүүдлийн Соёлт Дэлхийн Улс”-ын Нийгэм Соёлыг төлөөлөх эрх зүйт иргэн;
2. “Нүүдлийн Соёлт Дэлхийн Улс”-ын Нийгэм Улс Төрийн тэгш эрх зүйт иргэн;
3. “Нүүдлийн Соёлт Дэлхийн Улс”-ын Нийгэм Эдийн Засгийн эзэн эрх зүйт иргэн;

